



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот


Үнэт цаасны компаниудын үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий үнэт цаасны компаниудын үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Үнэт цаасны компаниудын үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж олон нийт, харьяалах татварын алба болон Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны  
.5 дугаар сарын 23-ны өдрийн 133 дугаар  
тогтоолын хавсралт



№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл
1	“Мэргэн санаа ҮЦК” ХХК	2081911	Дилер
2	“Таван богд ҮЦК” ХХК	2003678	Дилер
3	“Тулгатчандмань баян ҮЦК” ХХК	4000471	Дилер